




ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ

2025
№5



ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ



ГЭНЭТИЙН ОСЛЫН, ЭМЧИЛГЭЭНИЙ ДААТГАЛ ГЭЖ ЮУ ВЭ?



Аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас хүний **амь нас, эрүүл мэндэд** хохирол учрахад даатгалын үнэлгээнээс хамааран нөхөн төлбөр олгох зорилго бүхий **сайн дурын даатгал** юм. Үүнд: хөдөлмөрийн чадвар сэргэх хүртэлх хугацааны эмчилгээний зардал зэрэг хамаарна.

Даатгалд хамрагдах эрсдэлийн төрлүүд



Ахуйн эрсдэл

Элдэв зүйлд зохиулах, дарагдах, хавчигдах, явганаас унаж бэртэх, халтирах, машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцах үед гал, шаталт, дэлбэрэлтийн нөлөөгөөр учирсан гэмтэл, бэртэл, түлэгдэлт;

Аянга буух, хүчтэй салхи, цасан болон шороон шуурга, аадар бороо, мөндөр, усны үер, газар хөдлөлт болон ой хээрийн түймэр гэх мэт;



Байгалийн эрсдэл



Мал амьтдын
нөлөөгөөр үүсэх
эрсдэл

Морь малаас унах, чирэгдэх, хазуулах, араатан амьтан, нохойд уруулах, хортой шавж болон хачиг, нисдэг биетэд хазуулах, могойд хатгуулах гэх мэт;



Зам тээврийн хөдөлгөөнд оролцох үеийн эрсдэл

ХҮҮХДИЙН ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛ

Манай улсын нийт хүн амын 38.8 хувийг 0–19 насны хүүхдүүд эзэлдэг. Сүүлийн гурван жилийн дунджаар 40 гаруй мянган хүүхэд сургууль, цэцэрлэг болон ахуйн орчинд аливаа гэнэтийн осолд өртсөн байна.



Хүүхдээ аюулгүй байлгаж, ирээдүйг нь хамгаалъя



Гэнэтийн ослын даатгалын үйлчлэх хүрээ:

- Сургууль, олон нийтийн гудамж талбай болон ахуйн бүх орчинд 24 цаг үйлчилнэ.
- Гэнэтийн ослын даатгалд хүүхэд бүр хамрагдах боломжтой.
- Гэмтэл бэртлээс үүдэлтэй эм тариа, эмчилгээний зардлыг даатгагчаас олгодог.

Хүүхдийн даатгалын бүтээгдэхүүнүүд:



**Хүүхдийн гэнэтийн
ослын даатгал**



**Боловсролын
хуримтлалын даатгал**



**Хурдан морь унаач
хүүхдийн даатгал**



**Хуримтлалын
даатгал**

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХДАА ЮУ АНХААРАХ ВЭ?



Хэрэв та зуучлалын үйлчилгээ авахаар шийдсэн бол дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй эсэхийг нягтлах; /www.frc.mn/
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын брокер, агент нь “Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын мэргэжилтний эрх олгох сургалт” –д хамрагдаж гэрчилгээ авсан эсэхийг тодруулах;
- Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагатай байгуулах гэрээний төрөл, зүйл заалтыг бүрэн уншиж, танилцах;



Гэрээнд дараах зүйлс тусгагдсан байх бөгөөд заавал бичгээр байгуулж, гарын үсгээр баталгаажуулах хэрэгтэй:

- ✓ Талуудын нэр, оршин суугаа хаяг;
- ✓ Гэрээ байгуулсан он, сар, өдөр;
- ✓ Зуучлалын хөлс тодорхой тусгах;

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын гэрээний төрөл

Зуучлалын гэрээ

Зуучлах онцгой эрхийн гэрээ

ЗУУЧЛАЛЫН ГЭРЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?



Зуучлалын гэрээгээр зуучлагч нь зуучлуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үүрэг хүлээнэ.

Иргэний хуулийн 410.1 зүйл

ЗУУЧЛАХ ОНЦГОЙ ЭРХИЙН ГЭРЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?



Зуучлах онцгой эрхийн гэрээгээр зуучлуулагч нь тодорхой хугацааны турш өөр зуучлагчийн үйлчилгээнээс татгалзах, зуучлагч энэ хугацаанд гэрээ байгуулахад туслалцаа үзүүлэх үүргийг хүлээнэ.

Өөрөөр хэлбэл энэ гэрээний дагуу зуучлуулагч тодорхой хугацаанд өөр зуучлагчтай хамтран ажиллахгүй.

Иргэний хуулийн 411.1 зүйл

Зуучлалын гэрээ болон зуучлах онцгой эрхийн гэрээний гол ялгаа юу вэ?



Зуучлалын гэрээ

- Хугацааг харилцан тохиролцоогүй бол хэдийд ч цуцалж болно.
- Хөлс, шагналын хэмжээг харилцан тохиролцоогүй бол тогтсон нийтлэг жишиг хэмжээгээр тохиролцсон гэж үзнэ.
- Зуучлуулагч нь өөр зуучлагчтай хамтран ажиллах эрхтэй.



Зуучлалын гэрээ

- Зөвхөн онцгой нөхцөл үүссэн үед цуцална. /Онцгой нөхцөл гэдэгт иргэний хуулийн 221 дүгээр зүйл/ зуучлах хугацаа зургаан сар өнгөрсөн бол хугацаа харгалзахгүйгээр цуцлах боломжтой.
- Худалдах – худалдан авах гэрээний зуучлалын хөлс 5%-аас хэтрэхгүй байх.



REIT БУЮУ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САН ГЭЖ ЮУ ВЭ?



REIT /Real estate investment trust/ нь үл хөдлөх хөрөнгө худалдан авч борлуулах, түрээслэх хэлбэрээр орлого олдог, ногдол ашиг хуваарилдаг, эрсдэл багатай, тогтмол орлоготой санхүүгийн хэрэгсэл юм.



REIT нь нээлттэй, хаалттай хэлбэрээр байдаг бөгөөд хамтын хөрөнгө оруулалтын сангийн адилаар нэгж эрх гаргаж, хөрөнгө оруулагчдаас санхүүжилтийн эх үүсвэр татдаг, нэгж эрх нь олон нийтийн дунд нээлттэй арилжаалагддаг.

REIT-ЫН ДАВУУ ТАЛ



Тогтмол өгөөжтэй




Эрсдэл багатай



Хөрвөх чадвар өндөртэй



Хөрөнгө оруулалтын багцаа төрөлжүүлэх боломжтой.



REIT-ын менежментийг үл хөдлөх хөрөнгөөр мэргэшсэн, хөрөнгийн удирдлагын компани хийдэг.

REIT-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОГЧИД



REIT-ын менежер

REIT-ын хөрөнгийг удирдаж, үл хөдлөх хөрөнгө худалдан авах эрх, үүргийг хэрэгжүүлдэг.



Үл хөдлөх хөрөнгийн менежер

Үл хөдлөх хөрөнгийн маркетинг, сурталчилгаа болон засвар үйлчилгээтэй холбоотой эрх, үүргийг хэрэгжүүлдэг.



Trustee буюу итгэмжлэгдсэн өмчлөгч

REIT-ын нэрийн өмнөөс хөрөнгө эзэмших үүрэгтэй ба нэгж эрх эзэмшигчдийн ашиг сонирхлыг төлөөлдөг.

НОГООН ЗЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

“Ногоон зээл” бол байгаль орчинд ээлтэй, эрчим хүч, ус, дулаан хэмнэх эсхүл хүлэмжийн хийг бууруулах зориулалттай төслийг санхүүжүүлэх, байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад зориулагдсан тусгай нөхцөлтэй зээл юм.



Жишээ нь та **“Ногоон зээл”**-ийг дараах **байгальд ээлтэй** хөрөнгө оруулалтад ашиглах боломжтой:

- Байшингаа дулаалж дулааны алдагдлыг бууруулах, эрчим хүчний хэмнэлттэй халаагуур худалдан авах;
- Нарны хавтан эсхүл салхин сэнс зэрэг сэргээгдэх эрчих хүчний эх үүсвэр худалдан авах;
- Цахилгаан тээврийн хэрэгсэл, унадаг дугуй худалдан авах;
- Ногоон барилга, амины орон сууц барих, худалдан авах гэх мэт.




Яагаад ногоон зээлийг сонгох хэрэгтэй вэ?



Хүүгийн хөнгөлөлт: Зарим банк, санхүүгийн байгууллага ногоон зээлд энгийн зээлээс бага хүү санал болгодог.



Өсөн нэмэгдэх өгөөж: Та байгаль орчинд ээлтэй хэрэглээг сонгосноор эрчим хүч, ус, түлшний хэрэглээг бууруулан, хэмнэлт хийх боломжтой, мөн байгальд ээлтэй хөрөнгийн үнэ цэнэ улам бүр өсөж байна.

Ирээдүйн хөрөнгө оруулалт: Та байгальд ээлтэй сонголт хийснээр өөрийн болон ирээдүй үеийн амьдрах орчныг сайжруулж, эх дэлхийгээ хамгаалж буй юм.



Дэлхийн хэмжээнд хийгдсэн ногоон төсөл, зээлийн үр дүнд жил бүр **1 тэрбум тонн** нүүрстөрөгчийн давхар исэл CO_2 буурч байна (*Дэлхийн эрчим хүчний хөрөнгө оруулалтын тайлан 2023*). Энэ нь **200 сая ширхэг машин 1 жил яваагүйтэй**, дэлхийн хүн бүр таван мод тарьсантай ижил юм.

Дэлхийн банкны мэдээллээр **ногоон зээлийн тусламжтайгаар санхүүжүүлсэн барилга**, үйлдвэрүүд дунджаар **эрчим хүчний хэрэглээгээ 20–30% бууруулсан** (*Ногоон барилгын үр дүнгийн тайлан 2022, Дэлхийн банк*)



Олон улсын судалгаагаар 2023 онд дэлхий даяар **250 сая өрх** нарны хавтан ашиглаж эхэлсэн. **Нарны хавтанг суурилуулсан нэг айл жилд дунджаар 1,200 кг CO_2 хэмнэдэг**. Энэ нь **Ази тивийн 10 гаруй том хотыг бүтэн жил утаагүй** байлгасантай тэнцэх юм.

(*Сэргээгдэх эрчим хүчний хүчин чадлын статистик 2023, Олон улсын Сэргээгдэх эрчим хүчний агентлаг, болон Нарны хавтангийн хэмнэлт тайлан 2023, Олон улсын эрчим хүчний агентлаг*)



Ногоон зээл авахдаа юуг анхаарах вэ?

- ◆ Ногоон зээлийг зориулалтаас өөр зүйлд зарцуулалгүй, төлбөрөө цаг тухайд нь төлөөрэй.
- ◆ Ногоон төсөл, бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой бичиг баримтаа хадгалаарай (үнийн санал, суурилуулалтын гэрэл зураг, эрчим хүчний хэмнэлтийн тайлан гэх мэт).
- ◆ Банк, санхүүгийн байгууллага ногоон төсөл, ногоон бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг тань шалгаж, “ногоон” үр дүн гарч буйг баталгаажуулах хэрэгцээ гардаг тул идэвхтэй хамтран ажиллаарай.
- ◆ Ногоон зээлд хамрагдсанаар гарч буй эерэг өөрчлөлт, эрчим хүчний хэмнэлтийн туршлагаа бусадтайгаа хуваалцан, эерэг нөлөөлөл үзүүлээрэй.
- ◆ Ногоон зээл нь зээл биш, таны гэр бүл, нийгэм, ирээдүйдээ хийж буй урт хугацааны хөрөнгө оруулалт юм шүү.

ХИЙМЭЛ ОЮУН УХААН ГЭЖ ЮУ ВЭ?

Хиймэл оюун ухаан (ХОУ) буюу Artificial Intelligence (AI) нь хүн шиг **сэтгэх, суралцах, шийдвэр гаргах** чадвартай машин, програм хангамж юм.

Хиймэл оюун ухаан




1950–1970

Нейрон сүлжээ

Хүний тархитай төстэй. Оролт (өгөгдөл) аваад, дүгнэлт гаргадаг.

Жишээ: Зураг дээрх тоо ямар цифр вэ гэдгийг танина.



1980–2010

Машин сургалт

Компьютер өгөгдөлд өөрөө суралцаж, дараа нь таамаг гаргаж чадна.

Жишээ: Банк хүнд зээл олгох уу, үгүй юу гэдгийг өгөгдөл дээр үндэслэж шийднэ.



2011–2020

Гүн сургалт

Нарийн, төвөгтэй мэдээллийг ойлгож, илүү нарийвчилсан дүгнэлт гаргаж чадна.

Жишээ: Хүний яриаг ойлгоод хариулт өгөх; Нүүр царай таних.



2021–с хойш

Үүсгэх хиймэл оюун ухаан

Өгөгдөлд үндэслэн шинэ зүйл бүтээж чадна.

Жишээ: Танилцуулга бэлтгэх; Зураг зурах; Видео, дуу үүсгэх.

Хиймэл оюун ухаан нь бидний эргэн тойронд аль хэдийн байр суурь эзэлж, хэрэглээний салшгүй хэсэг болжээ.



NETFLIX



ChatGPT



amazon

Санхүүгийн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ

Санхүүгийн салбарыг хиймэл оюун ухаан, их хэмжээний өгөгдөл зэрэг технологийн олон төрлийн хөгжил дэвшил нь эрчимтэйгээр өөрчилж байна.



Хиймэл оюун ухаанд суурилсан залилан илрүүлэлт ба аюулгүй байдал

Сэжигтэй гүйлгээг бодит цаг хугацаанд илрүүлж, зогсооход тусалж байна.

Зээлийн автомат боловсруулалт ба зээлийн оноо тогтоох

Хэрэглэгчийн орлого, зээлийн түүх, төлбөрийн сахилга бат зэрэг өгөгдлийг задлан шинжилж, зээлийн эрсдэлийг тооцож шударга, үр ашигтай үнэлгээ хийхэд тусалж байна.



Гүйлгээний урьдчилсан таамаглал бүхий дүн шинжилгээ

Хэрэглэгчийн гүйлгээний мэдээлэлд үндэслэн ирээдүйн хэрэглээний хэв маягийг урьдчилан таамаглаж байна.

Автоматжуулсан нийцэл шалгалт ба эрсдэлийн менежмент

Хууль, журамтай уялдуулан өгөгдлийг байнга шалгаж, зөрчлийг автоматаар илрүүлж байна.



Хувь хүнд тохируулсан санал, зөвлөмжүүд


Өмнөх гүйлгээ, хадгаламж, хэрэглээний хэв маягт үндэслэн тохирсон санхүүгийн бүтээгдэхүүн, зөвлөмжийг санал болгож байна.

МӨНГӨ УГААХ ГЭЖ ЮУ ВЭ?



“МӨНГӨ УГААХ” ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ:

Анх Америкийн гэмт хэрэгтэн Аль Капоне гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөө хууль ёсны орлого мэт харагдуулах зорилгоор Чикаго хотын хими цэвэрлэгээ, угаалгын газруудыг ашигладаг байснаас “Мөнгө угаах” буюу “Money Laundering” гэх нэр томъёо үүсжээ.



Мөнгө угаах гэдэг нь гэмт хэрэг үйлдэж олсон орлогын эх үүсвэрийг нуун далдалж уг орлогыг хууль ёсны мэтээр халхавчлан эдийн засгийн эргэлтэд оруулах бүхий л үйл ажиллагаа юм.



МӨНГӨ УГААХ ҮЕ ШАТ

Байршуулах үе: Хууль бус орлогыг хууль ёсны санхүүгийн системд байршуулах

Далдлах үе: Мөнгөний гарал үүслийг нуух зорилгоор олон төрлийн гүйлгээ хийх, данс хооронд шилжүүлэх, бэлэн мөнгө хил дамнуулан шилжүүлэх, санхүүгийн хэрэгсэл, хөрөнгө зэргийг худалдах, шилжүүлэх, солилцох гэх мэт.

Буцааж нэгтгэх үе: Эх үүсвэрийг хангалттай далдалсны дараа хууль ёсны орлого мэтээр буцаан төвлөрүүлж авах үе шат (Тансаг зэрэглэлийн бараа, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, томоохон бизнес, төсөл зэрэгт хөрөнгө оруулах гэх мэт)

ХУУЛЬ БУС
ОРЛОГО



1. БАЙРШИЛ



ЭДИЙН ЗАСГИЙН
ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ



3. БУЦААН
ТӨВЛӨРҮҮЛЭХ



2. НУУН ДАЛДЛАХ



Мөнгө угаах болон
терроризмыг санхүүжүүлэхтэй
тэмцэх тухай хуультай
танилцаарай

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭЖ ЮУ ВЭ?



Терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь терроризм үйлдэхээр санаархаж, төлөвлөж эсхүл оролцох гэж буй этгээд, террорист бүлэглэл, үйл ажиллагаанд зориулан хууль ёсны болон хууль бус хөрөнгө, орлогыг хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулах үйл ажиллагаа юм.



МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРЭГ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ЯЛГАА

МӨНГӨ УГААХ ҮЕ ШАТ

Хууль бус орлогыг хууль ёсны юм шиг харагдуулахыг зорьдог.

ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ

Хууль ёсны болон хууль бус орлогыг террорист үйл ажиллагаанд зарцуулахыг хэлдэг.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь арга хэлбэрийн хувьд ижил төстэй, хоорондоо холбоотой үйлдэгддэг хэдий ч гэмт хэргийн сэдэл, эх үүсвэр, эцсийн зорилгоор ялгагддаг. Тухайлбал, мөнгө угаах гэмт хэрэг нь хууль бус орлогыг хууль ёсны болгох замаар ашиг хонжоо олохыг зорьдог бол терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг нь хууль ёсны болон хууль бус орлогоор санхүүжиж террорист үйл ажиллагааг дэмжих зорилготой.


Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаад хяналт тавих байгууллага

№	Санхүүгийн зохицуулах хороо	Монголбанк
1	Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)	БАНК
2	Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч	
3	Хөрөнгө оруулалтын сан (ХОС)	
4	Үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага	
5	Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)	
6	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага	
7	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч	
8	Үнэт металл, үнэт эдлэл эрхлэгч	
9	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэгч	



ЗЭЭЛИЙН БАТЛАН
ДААЛТЫН САН

ОРОН НУТГИЙН ИПОТЕКИЙН ЗЭЭЛИЙН УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙН БАТЛАН ДААЛТ



Зорилго

- 🎯 Улаанбаатар хотын хэт төвлөрлийг сааруулах
- 🎯 Орон нутгийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих
- 🎯 Иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх
- 🎯 Урьдчилгаа төлбөр болон барьцаа хөрөнгө хүрэлцэхгүй иргэдэд батлан даалт гаргах.

Хамрах хүрээ

- 📌 Монгол Улсын 21 аймаг
- 📌 Налайх, Багануур, Багахангай дүүрэг



Ипотекийн зээлийн батлан даалтын нөхцөл

Зээлийн хүү: 6%
Зээлийн хугацаа: 360 сар
Зээлийн хэмжээ: 150 сая төгрөг хүртэл
Батлан даалтын хувь: 60% хүртэл
(Урьдчилгаа төлбөрийн)



(2025 оны 7-р сарын 29-ний байдлаар)



Дэлгэрэнгүй мэдээллийг: 7700-2035

Батлан даалт хүсэгчид тавигдах ерөнхий шаардлага



- ✓ 18 нас хүрсэн Монгол Улсын иргэн;
- ✓ Орон сууцны ипотекийн зээл, эсвэл “түрээслээд өмчлөх” хөтөлбөрт хамрагдаж байгаагүй байх;
- ✓ Хамтран зээлдэгч нь ипотекийн хөнгөлөлттэй зээлийн үлдэгдэлгүй байх;
- ✓ Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өргүй байх;
- ✓ Өр төлбөр болон татварын үлдэгдэлгүй байх;
- ✓ 1 жилээс дээш тогтвор суурьшилтай ажилласан байх. Хувиараа бизнес эрхлэгч бол тухайн үйл ажиллагаагаа 2 ба түүнээс дээш жил эрхэлсэн байх;
- ✓ Сар бүрийн зээлийн эргэн төлөлт нь өрхийн татварын өмнөх орлогын 45 хувиас ихгүй байх;
- ✓ Батлан даалтын гэрээний хугацаанд эд хөрөнгө болон амь насны даатгалд бүрэн хамрагдах.

Батлан даалтанд хамрагдах орон сууцанд тавигдах шаардлага

- ✓ Нийт талбайн хэмжээ 80 м²-аас бага байх;
- ✓ Инженерийн дэд бүтцийн шийдэлтэй байх;
- ✓ Үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байх;
- ✓ Эд хөрөнгө болон түүнтэй холбоотой эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэх шаардах эрх үүсээгүй байх.



Шимтгэл, хураамж

Шимтгэл:	Жил бүр батлан даалтын үлдэгдэл дүнгийн 1%
Үйлчилгээний хураамж:	10,000 төгрөг



Дэлгэрэнгүй мэдээллийг: 7700-2035

(2025 оны 7-р сарын 29-ний байдлаар)



ФАТФ–ЫН ХАР, СААРАЛ ЖАГСААЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

ФАТФ (Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага) нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) олон улсын стандартыг боловсруулж, хэрэгжилтийг нь хянадаг байгууллага юм.



ФАТФ–аас улс, орнууд зөвлөмж, стандартыг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавьж, хангалтгүй улс орнуудыг **хар** болон **саарал** жагсаалтад оруулдаг болсон бөгөөд энэ нь тухайн улсын санхүүгийн нэр хүндэд шууд сөргөөр нөлөөлдөг.

ХАР БОЛОН СААРАЛ ЖАГСААЛТЫН ЯЛГАА

СААРАЛ ЖАГСААЛТАД: мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь сул, гэхдээ сайжруулах амлалт өгсөн, ФАТФ–тай хамтран ажиллаж буй орнууд багтдаг

ХАР ЖАГСААЛТАД: мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь ноцтой дутагдалтай, хамтран ажиллахаас татгалзсан улс орнууд багтдаг

ФАТФ–тай хамтын ажиллагаатай



ФАТФ–тай хамтын ажиллагаагүй

Эрсдэлийн түвшин дунд



Эрсдэлийн түвшин өндөр

Эрчимжүүлсэн хяналт шалгалтын арга хэмжээ авах




Хориг арга хэмжээ авах



МОНГОЛ УЛС

Монгол Улс 2013 онд анх ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орж, 2014 онд гарсан. Мөн 2017 оны үнэлгээгээр 20 зөвлөмж хангалтгүй хэрэгжсэн нь үнэлэгдсэн тул 2019 онд дахин “саарал жагсаалт”-д орсон. Улмаар 1 жилийн хугацаанд ФАТФ-тай идэвхтэй хамтран ажиллаж, өгсөн үүрэг, даалгавруудыг бүрэн биелүүлсний үр дүнд 2020 онд саарал жагсаалтаас гарсан.



2023 оны 9 дүгээр сард Монгол Улс ФАТФ-ын 40 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн Азийн анхны орон болсон.

МУТСТ ЧИГЛЭЛЭЭР ӨНДӨРЖҮҮЛСЭН ХЯНАЛТАД ОРСОН ОРНЫ ЖАГСААЛТ (2025 оны 06 дугаар сарын байдлаар)

СААРАЛ ЖАГСААЛТ



Алжир



Ангол



Боливи



Болгар



Буркина Фасо



Камерун



Кот-д'Ивуар



Конго



Хаити



Кени



Лаос



Ливан



Монако



Мозамбик



Намиби



Өмнөд Африк



Балба



Нигери



Сири



Өмнөд Судан



Венесуэл



Вьетнам



Йемэн



Виржинийн арлууд

ХАР ЖАГСААЛТ



БНАСУ



Иран



Мьянмар

МУТСТ дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл



МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Санхүүгийн байгууллагууд нь хэрэглэгчдийн мөнгө, данс, төлбөрийн мэдээлэл болон бусад хувийн мэдээллийг аюулгүй хадгалах, мэдээллийг зөвшөөрөгдсөн хүрээнд ашиглах, мөн алдагдахаас хамгаалах үүрэгтэй.

Мэдээллийн аюулгүй байдал гэдэг нь таны мэдээллийг хууль бус хандалт, кибер халдлага, алдагдлаас хамгаалах арга хэмжээ юм.



Мэдээллийн аюулгүй байдлын үндсэн зорилго



Мэдээллийн нууцлал

Харилцагчийн мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулахгүй байх.



Мэдээллийн бүрэн бүтэн байдал

Мэдээллийг алдагдуулах, өөрчлөх, устгахгүй байх.



Мэдээллийн хүртээмжтэй байдал

Хэрэглэгчид шаардлагатай үед мэдээлэлд хандах боломжтой байх.

Санхүүгийн байгууллагаас таны мэдээллийн нууцлалыг хангах хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлдэг:



Хувийн мэдээллийг зөв ашиглах

Хэрэглэгчийн хувийн мэдээллийг гуравдагч этгээдэд зөвшөөрөлгүйгээр хуваалцахгүй байх.



Удирдлагын арга хэмжээ

Мэдээллийн хамгаалалтын дүрэм, бодлого боловсруулах, ажилтны сургалт зохион байгуулах, эрсдэлийн үеийн төлөвлөгөөтэй байх.



Хэрэглэгчийн итгэлийг хадгалах

Мэдээлэл алдагдсан тохиолдолд хэрэглэгчдэд мэдээлэх, аюулгүй байдлыг хангах зөвлөмж өгөх.



Техникийн хамгаалалт

Мэдээллийг шифрлэх, олон шатлалтай баталгаажуулалт хийх, цахим халдлагыг илрүүлэх систем ашиглах.



Хууль, дүрэм журмыг мөрдөх

Холбогдох хууль, дүрмийг дагаж мөрдөх, зөрчлөөс урьдчилан сэргийлэх.



ХУВИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХАМГААЛАХ ЗӨВЛӨМЖҮҮД



1. Хүчтэй нууц үг ашиглах

Том, жижиг үсэг, тоо, тэмдэгт хослуулсан, давтагдашгүй нууц үг нь таны санхүүгийн болон хувийн мэдээллийг халдлагаас хамгаална. Хүчтэй нууц үг нь таамаглахад хэцүү бөгөөд олон цахим хуудаст давтан ашиглахгүй байх нь чухал.

2. Хоёр шатлалт баталгаажуулалт идэвхжүүлэх

Энэ нь зөвхөн нууц үгээр нэвтрэхийг бус, нэмэлт баталгаажуулалтын шат нэмж оруулах арга юм. Жишээ нь, нэвтрэх нууц үгээс гадна өөрийн гар утас болон бусад баталгаажуулалтын хэрэгслийг ашиглан давхар нэг удаагийн код ашиглах юм.



3. Найдвартай сүлжээ хэрэглэх

Санхүүгийн гүйлгээг зөвхөн хувийн, хамгаалалттай утасгүй сүлжээ, интернэт эсвэл мобайл дата ашиглан хийх нь мэдээлэл алдахаас сэргийлдэг. Нийтийн утасгүй сүлжээ ашиглах нь мэдээлэл алдагдах өндөр эрсдэлтэй байдаг.

4. Мэдээллээ хадгалахгүй байх

Цахим хуудас, утасны аппликэйшн дээр нууц үгээ автоматаар хадгалах тохиргоог ашиглахгүй байх нь мэдээлэл алдагдахаас урьдчилан сэргийлдэг.



Мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой баримт:

- * Дэлхий дахинд мэдээлэл алдагдсаны **дундаж өртөг 2025 оны байдлаар 4.44 сая ам.долларт** хүрсэн байна. (IBM, Cost of a data breach, 2025)
- * Мэдээлэл алдагдлын **81% нь сул, дахин ашигласан эсвэл хулгайлагдсан нууц үгтэй холбоотой** байна. (Verizon Data Breach Report, 2025).
- * Сул нууц үг хэрэглэх, нууц үгийг олон системд давтаж ашиглах, тогтмол шинэчлэхгүй байх, хоёр шатлалт баталгаажуулалт (2FA)–ыг хэрэгжүүлэхгүй байх зэрэг муу дадлууд мэдээллийн аюулгүй байдалд хамгийн том эрсдэл учруулдаг. (Verizon Data Breach Report, 2025)



САНХҮҮГЭЭ ХЭРХЭН ТӨЛӨВЛӨХ ВЭ?



Бид “санхүүгийн төлөвлөлт”–ийг дараах 6 үе шаттайгаар хийх боломжтой. Ингэснээр орлогоо зохистой хуваарилж, зардлаа хянах замаар **хуримтлал** үүсгэж болно.

1

Одоогийн нөхцөл байдлаа үнэлэх.

Орлого, зарлагаа тооцож, санхүүгийн бодит байдлаа тодорхойлох.

2

Зорилгоо тодорхойлох.

Хуримтлал үүсгэх зорилго, хугацаа, хэрэгцээг тодорхойлох.

3

Санхүүгийн төлөвлөгөө зохиох.

Зорилгодоо хүрэх хугацаа, үе шатыг төлөвлөх.

4

Төлөвлөгөөг хэрэгжүүлэх.

Санхүүгийн төлөвлөгөөг сахилга баттайгаар хэрэгжүүлж, зардлаа хянах.

5

Төлөвлөгөөг эргэн харах, залруулах.

Цаг хугацааны явцад гэнэтийн нөхцөл байдал үүсвэл төлөвлөлтөд-залруулга хийх.

Эх сурвалж: "Санхүүгийн хөтөч" ном

САНХҮҮГЭЭ УДИРДАХ АРГУУД

Бид дараах аргуудаар орлогоо төлөвлөж болох юм...




50/20/30 ДҮРЭМ

ХАДГАЛАМЖ



ЧӨЛӨӨТ ЗАРЦУУЛАЛТ

- Гадуур гарах
- Ресторан орох
- Худалдан авалт хийх



ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРДАЛ

- Зээл
- Түрээс
- Хүнс
- Эрүүл мэнд
- Тээвэр гэх мэт

50/15/5 ДҮРЭМ

Хэрэглээний зардал



50%

Урт хугацаат хуримтлал



15%

Гэнэтийн хэрэгцээнд зориулсан хуримтлал



5%



30%

Чөлөөт зарцуулалт

САНХҮҮГЭЭ ТӨЛӨВЛӨХИЙН АЧ ХОЛБОГДОЛ



1

Өрийн дарамтад орохоос сэргийлэх.

2

Орлого, зардлаа удирдаж сурах.

3

Хуримтлалтай болох.

4

Санхүүгийн хувьд бусдаас хараат бус болох.

5

Санхүүгийн сахилга баттай болох.

6

Ирээдүйн зорилгодоо хүрэх боломж нэмэгдэх.

МӨНГӨ ХҮҮЛЭЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Хуулиар тогтоосон хэмжээнээс давсан, үндэслэлгүй өндөр хүүтэй мөнгө зээлдүүлэх явдал.



Мөнгө хүүлэх нийтлэг аргууд:

1

Өндөр хүү – Зээлийн хүү ердийн хэмжээнээс өндөр, хүүгийн мэдээлэл өгөхөөс зайлсхийх;

2

Нэмэлт шимтгэл, торгууль авах – Зээлийн гэрээнд олон жижиг заалт оруулж нэмэлт төлбөрүүд ногдуулах. Жишээ нь: бичиг баримтын шимтгэл, хугацаа хэтрүүлсний өндөр торгууль, заавал даатгал гэх мэт;

3

Богино хугацаатай зээл – 7–30 хоногийн хугацаатай, хугацаандаа төлж чадахгүй бол нэмэгдэл торгууль оногдуулж хуримтлагдаж өр үүсгэх;

4

Барьцаагаар дарамтлах – Барьцааг бодит үнээс нь бага үнэлэх, түүнийг буцаан авах нөхцөл тодорхой бус, мөн зээлийн хугацаа дуусмагц барьцааг өөрт ашигтайгаар хураан авах;

5

Дарамт, заналхийллийн тактик ашиглах – Зээлээ төл гэж байнга залгах, айлган сүрдүүлэх, бичиг баримт хурааж дарамтлах;

6

“Давхар зээл” олгох – Зээлээ төлөхийн тулд дахин зээл авахыг шаардах;

7

Барьцааг зориуд хураах зорилготой зээл олгох – Зээлийн хугацаа дуусмагц барьцааг хураах нөхцөлтэй.

Мөнгө хүүлэлтээс өөрийгөө сэргийлье!



Зээл олгож буй байгууллага, хувь хүн нь албан ёсны тусгай зөвшөөрөлтэй байх;



Хууль, эрх зүйн зохицуулалтын мэдлэгтэй байх;



Хүү, шимтгэл, торгууль, хугацаа, нөхцөл зээлийн гэрээнд бүрэн тусгагдсан байх;



Орлого, зарлагаа бодитой тооцож эргэн төлөх боломжоо тодорхойлох;



Хөрөнгийг бодит үнээс хэт багаар үнэлж барьцаалах;



Өмнөх зээлээ хаахын тулд дахин зээл авахгүй байх;

Хэрэв мөнгө хүүлэлтэд өртсөн бол:

1

Өргөдөл гаргана. Үүнд:
Овог, нэр, оршин суугаа газрын хаяг, цахим шуудангийн хаяг, утасны дугаар, огноо өргөдөл бичих болсон шалтгаан зэргийг тусгаж гарын үсгээ зурж баталгаажуулна.

2

Өргөдөлд дурдсан шалтгааныг нотлох холбогдох баримт бичгийг хавсаргана. Үүнд:

- Зээлийн гэрээ
- Дансны хуулга
- Бусад

3

Гомдол, холбогдох баримт бичгээ хүргүүлэх:



Монополын эсрэг газар	Санхүүгийн зохицуулах хороо	Цагдаагийн байгууллага
Хэрэглэгчийн эрх зөрчигдсөн /өндөр хүү, нууц шимтгэл, шударга бус зээлийн нөхцөл, санхүүгийн үйлчилгээний гэрээний нөхцөл/	Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай этгээд /ББСБ, ХЗХ, МЗҮАЭ/ хууль бус үйлдэл, өндөр хүүтэй зээл, санхүүгийн үйлчилгээний гэрээний нөхцөл зөрчигдсөн, эрхэнд халдсан гэх мэт	Хууль бус барьцаа авах, хөрөнгө булаах оролдлого, сүрдүүлэг, хүч хэрэглэсэн гэх мэт гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл харьяа цагдаагийн байгууллагад хандах
Холбоо барих утас: 51263225, Цахим хаяг: contact@ama.gov.mn Байршил: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IXа байр	Холбоо барих утас: 51-264444, 51-261275 (Өргөдөл, гомдол хүлээн авах), Цахим хаяг: info@frc.mn Байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3, Засгийн газрын IV байр	102



Хууль, гэрээнд заасан эрх ашиг зөрчигдсөн болон торгуулийг хүчингүй болгуулах, хууль бус үйлдлийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг нөхцөлд харьяаллын дагуу шүүхэд хандана.

ЦАХИМААР ҮНЭТ ЭДЛЭЛ ХУДАЛДАН АВАХ НЬ ЯМАР ЭРСДЭЛТЭЙ ВЭ?



Цахим орчноос үнэт эдлэл худалдан авснаар танд үүсэж болзошгүй **ЭРСДЭЛҮҮД**:



Хуурамч бүтээгдэхүүн байх – Үнэт металл бус энгийн металлаар хийгдсэн, сорьцын баталгаагүй, дуураймал бүтээгдэхүүн байх магадлалтай!



Баталгаагүй борлуулагч байх – Үнэт чулуу болон үнэт эдлэл худалдан борлуулах тусгай зөвшөөрөлгүй, хаяг байршил нь тодорхойгүй хувь хүнээс худалдан авах нь эрсдэлтэй!



Буцаалт болон хохирлыг нөхөн олгохгүй байх – Таны худалдан авсан бараа шаардлага хангахгүй тохиолдолд барааг буцаахгүй, хохирлыг нөхөн төлөхгүй байх магадлалтай!



Зохиомлоор яаралтай нөхцөл байдал үүсгэх – “Хямдралтай”, “бараг дуусаж байна” гэх мэт гарчигтай зар нь таныг эрсдэлтэй худалдан авалт хийхэд хүргэж болзошгүй!



Зээлээр эсхүл урьдчилгаа авах нэрээр залилан хийх – Урьдчилгаа 50% төлөөд захиалга хийх нөхцөлтэй цахим залилан байх эрсдэлтэй!







ҮНЭТ ЭДЛЭЛ ХУДАЛДАН АВАХАД АНХААРАХ ЗҮЙЛС:



Зөвшөөрөлтэй хувь хүн, байгууллагаар үйлчлүүлэх – Баталгаатай, хаяг байршил нь тодорхой, тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээдээс авах.



Сорьц, гарал үүсэл, баталгааны бичгийг шалгах – Эрх бүхий байгууллагаас баталгаажуулсан сорьцын баталгааны тэмдэгтэй, эрдэнийн чулууны гэрчилгээтэй үнэт эдлэл худалдан авах.

Мөнгө	Алт Цагаан алт	Платина	Палладий
 925	 999 960 916 750 585 375 333	 950 900 850	 850 800



Буцаалт, баталгааны нөхцөлийг нягтлах – Үйлчилгээний нөхцөл, буцаалт, хөнгөлөлтийн нөхцөлийг сайтар уншиж, танилцах.



Үнийн бодит байдлыг харьцуулах – Зах зээлийн дундаж үнэтэй харьцуулан, хэт хямд үнэтэй чанаргүй бүтээгдэхүүн худалдан авахаас сэргийлэх.



Мэдээлэл авах – Тусгай зөвшөөрөлтэй холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, сорьцын талаарх мэдээллийг Стандарт хэмжилзүйн газраас авна уу.

Санхүүгийн зохицуулах хороо, Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газар

Утас: 51-262607, 51-262604

Цахим хуудас www.frc.mn

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, 15160

Стандарт хэмжилзүйн газар, Сорьцын хяналтын газар

Утас: 77005757, 75778430

Цахим хуудас www.mas.mn

Стандарт хэмжилзүйн газрын 1-р байр,

Энхтайваны өргөн чөлөө 46А, Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг дараах QR кодыг уншуулан шалгах боломжтой.





ИРГЭН ТАНЫ САНХҮҮГИЙН МЭДЛЭГТ



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia